

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням
Утас:329871 Цахим хаяг:Sambuunyamyа@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас:51-261628 Цахим хаяг: Bujinlkhandj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА С.БАТБААТАР
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1201
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ.

1. Хуульд заасан хугацаанд 767.1 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлангийн дүнгээс 219.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
2. Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 568.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;
3. Санхүүгийн тайланд 220.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг зөрүүтэй тайлагнаж, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан;
4. Төсвийн шууд захирагчийн татаас санхүүжилтийн авлагыг Сангийн яамтай эцэслэн тооцоо нийлээгүйгээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь байгууллагуудын аудит хийсэн тайлангаас нийт 373.1 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн;
5. Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны 144.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 72 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “оршин байх”, “ангилал”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар тушаалаар Стандарт, хэмжил зүйн салбараас үзүүлж байгаа ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан байна.

Стандарт, хэмжил зүйн газар болон харьяа байгууллагууд 2024 онд нийт 15,267.2 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлснээс Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 224 дүгээр тушаалаар төлөвлөгөөнөөс давсан 5,513.8 сая төгрөгийг зарцуулах эрхийг олгож, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Стандарт, хэмжил зүйн газар нь 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 4,002.5 сая төгрөгөөр баталж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3,378.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлж, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 624.5 сая төгрөгийн тавилга, эд хогшил нийлүүлэх тендерийг байгууллагадаа зохион байгуулж 8 хуулийн этгээдтэй 3,608.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Үл хөдлөх хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай” 33 дугаар тогтоолоор Шүүх шинжилгээний хэлтсийн 1,246.8 сая төгрөгийн үнэ бүхий барилгыг Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэст шилжүүлэн авсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САМБУУНЯМ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,881,114.7	3,687,602.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	37,673.0	84,473.8
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	220,260.9	788,288.2
УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	742,531.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,623,180.7	2,072,308.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		27,688,766.8	30,141,028.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	27,688,766.8	30,141,028.3
Биет хөрөнгө		26,559,929.1	28,737,590.2
Биет бус хөрөнгө	13	1,128,837.7	1,403,438.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		29,569,881.5	33,828,630.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР		270,643.9	76,595.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	270,643.9	76,595.2
Өглөг	17а, 17б	268,993.9	72,223.2
Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,650.0	4,372.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		29,299,237.6	33,752,035.2
Засгийн газрын хувь оролцоо		29,299,237.6	33,752,035.2
Засгийн газрын оруулсан капитал		9,474,838.1	9,474,838.1
Хуримтлагдсан үр дүн		17,701,022.9	22,153,820.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,123,376.5	2,123,376.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		29,569,881.5	33,828,630.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		32,674,625.2	40,641,648.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	19,290,208.7	14,475,658.9
Нийтлэг татварын бус орлого		19,290,208.7	14,475,658.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		13,384,416.5	26,165,989.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	25,518,732.7	36,177,555.2
УРСГАЛ ЗАРДАЛ		25,518,732.7	36,177,555.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		20,982,720.0	29,120,281.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,469,640.6	17,897,742.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,532,266.5	2,337,980.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,321,735.0	1,332,997.4
Хангамж, бараа материалын зардал		491,736.9	664,006.0
Нормативт зардал		602,821.7	695,786.5
Эд хогшил, урсгал засварын зардал		482,782.8	446,040.0
Томилолт, зочны зардал		341,740.6	652,298.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		646,451.6	1,371,733.6
Бараа үйлчилгээний бусад зардал		3,093,544.3	3,721,697.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,536,012.8	7,057,273.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		7,155,892.5	4,464,093.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		759,908.0	10,979.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		6,395,984.5	4,453,113.3

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,753,169.4	40,719,227.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,150,682.9	12,226,714.7
Нийтлэг татварын бус орлого	10,150,682.9	12,226,714.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,602,486.5	28,492,513.1
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,128,292.6	36,733,510.6
УРСГАЛ ЗАРДАЛ	23,128,292.6	36,733,510.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,579,664.0	27,360,348.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,448,270.0	17,998,388.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,564,531.5	2,258,520.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,119,567.7	1,534,602.0
Хангамж, бараа материалын зардал	367,004.2	538,077.4
Нормативд зардал	552,645.9	861,610.7
Эд хогшил, урсгал засварын зардал	694,445.2	1,378,698.9
Томилолт, зочны зардал	324,003.0	657,595.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	635,244.6	1,387,599.0
Бараа үйлчилгээний бусад зардал	873,951.7	745,255.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,548,628.6	9,373,162.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	624,876.8	3,985,717.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	615,477.3	3,938,916.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	615,477.3	3,938,916.4
Дотоод эх үүсвэрээр	615,477.3	3,938,916.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(615,477.3)	(3,938,916.4)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,399.5	46,800.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,273.5	37,673.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,673.0	84,473.8

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,571,624.7	-	11,571,624.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	11,331,628.4	-	11,331,628.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,903,253.1	-	22,903,253.1
Тайлант үеийн үр дүн	6,395,984.5	-	6,395,984.5
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,299,237.6	-	29,299,237.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(315.6)	-	(315.6)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,298,922.0	-	29,298,922.0
Тайлант үеийн үр дүн	4,453,113.3	-	4,453,113.3
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,752,035.2	-	33,752,035.2

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,754,878,300.00	29,016,115,257.37	738,763,042.63	97.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,376,878,300.00	26,011,943,187.37	364,935,112.63	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,562,251,400.00	24,398,337,487.17	163,913,912.83	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,238,805,800.00	17,201,561,640.74	37,244,159.26	99.8
210101	Үндсэн цалин	10,362,132,000.00	10,306,865,068.30	55,266,931.70	99.5
210102	Нэмэгдэл	4,191,333,100.00	4,113,959,103.93	77,373,996.07	98.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,442,552,400.00	1,491,824,096.70	(49,271,696.70)	103.4
210104	Урамшуулал	1,242,788,300.00	1,283,008,561.16	(40,220,261.16)	103.2
210105	Гэрээт ажлын хөлс	-	5,904,810.65	(5,904,810.65)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,141,361,000.00	2,134,504,365.24	6,856,634.76	99.7
210201	Тэтгэврийн даатгал	1,451,829,500.00	1,446,082,847.34	5,746,652.66	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	172,382,800.00	171,700,503.36	682,296.64	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	86,191,500.00	92,901,968.55	(6,710,468.55)	107.8
210204	Ажилгүйдлийн даатгал	86,191,500.00	85,554,322.18	637,177.82	99.3
210205	Эрүүл мэндийн даатгал	344,765,700.00	338,264,723.81	6,500,976.19	98.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,342,654,000.00	1,312,046,712.72	30,607,287.28	97.7
210301	Гэрэл, цахилгаан	234,052,500.00	212,627,991.25	21,424,508.75	90.8
210302	Түлш, халаалт	770,778,900.00	775,235,217.17	(4,456,317.17)	100.6
210303	Цэвэр, бохир ус	102,851,900.00	89,790,364.30	13,061,535.70	87.3
210304	Байрны түрээс	234,970,700.00	234,393,140.00	577,560.00	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	414,181,400.00	410,942,807.56	3,238,592.44	99.2
210401	Бичиг хэрэг	110,029,900.00	107,819,548.00	2,210,352.00	98.0
210402	Тээвэр, шатахуун	88,184,400.00	85,463,404.00	2,720,996.00	96.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,845,000.00	103,262,406.56	(2,417,406.56)	102.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,328,500.00	19,101,800.00	2,226,700.00	89.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	93,793,600.00	95,295,649.00	(1,502,049.00)	101.6
2105	Нормативд зардал	698,220,000.00	695,632,202.00	2,587,798.00	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	604,839,800.00	604,526,508.00	313,292.00	99.9
210502	Хоол, хүнс	74,145,100.00	71,959,084.00	2,186,016.00	97.1

Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,235,100.00	19,146,610.00	88,490.00	99.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	512,431,400.00	510,697,123.90	1,734,276.10	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	271,113,000.00	272,442,553.90	(1,329,553.90)	100.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	34,993,700.00	9,059,438.00	25,934,262.00	25.9
210604	Урсгал засвар	206,324,700.00	229,195,132.00	(22,870,432.00)	111.1
2107	Томилолт, зочны зардал	443,474,600.00	438,590,246.00	4,884,354.00	98.9
210702	Дотоод албан томилолт	443,474,600.00	438,590,246.00	4,884,354.00	98.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,391,236,200.00	1,316,679,479.58	74,556,720.42	94.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	962,142,300.00	894,437,501.58	67,704,798.42	93.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,138,200.00	8,098,100.00	1,040,100.00	88.6
210803	Даатгалын үйлчилгээ	8,092,600.00	6,817,483.00	1,275,117.00	84.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,654,600.00	2,083,760.00	1,570,840.00	57.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	721,900.00	520,200.00	201,700.00	72.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	251,436,900.00	251,003,341.00	433,559.00	99.8
210807	Газрын төлбөр	7,512,200.00	6,680,014.00	832,186.00	88.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	512,000.00	75,100.00	436,900.00	14.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	148,025,500.00	146,963,980.00	1,061,520.00	99.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	379,887,000.00	377,682,909.43	2,204,090.57	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	264,898,200.00	263,859,727.43	1,038,472.57	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	114,988,800.00	113,823,182.00	1,165,618.00	99.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,814,626,900.00	1,613,605,700.20	201,021,199.80	88.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	246,304,000.00	246,246,278.49	57,721.51	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	246,304,000.00	246,246,278.49	57,721.51	100.0

Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,568,322,900.00	1,367,359,421.71	200,963,478.29	87.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	758,510,400.00	566,225,484.71	192,284,915.29	74.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	726,250,800.00	719,902,675.00	6,348,125.00	99.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	83,561,700.00	81,231,262.00	2,330,438.00	97.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,378,000,000.00	3,004,172,070.00	373,827,930.00	88.9
222001	Тоног төхөөрөмж	3,378,000,000.00	3,004,172,070.00	373,827,930.00	88.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,376,878,300.00	29,016,115,257.37	(2,639,236,957.37)	110.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,015,680,500.00	19,262,662,042.86	(246,981,542.86)	101.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	19,015,680,500.00	19,262,662,042.86	(246,981,542.86)	101.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,361,197,800.00	9,753,453,214.51	(2,392,255,414.51)	132.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,350,283,800.00	9,743,039,214.51	(2,392,755,414.51)	132.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,914,000.00	10,414,000.00	500,000.00	95.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
610001	Төсвийн байгууллага	23	23	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	713	713	-	100.0
620001	Удирдах ажилтан	33	33	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	566	566	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	114	114	-	100.0

2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,703,034,270.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	6,534,940,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,733,212,495.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	796,827,243.58
210101	Үндсэн цалин	-	183,033,444.24
210102	Нэмэгдэл	-	521,143,400.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,109,000.00
210104	Урамшуулал	-	90,541,399.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	124,016,427.99
210201	Тэтгэврийн даатгал	-	96,721,171.43
210202	Тэтгэмжийн даатгал	-	6,253,706.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,035,068.33
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,762,167.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	14,244,314.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	222,555,274.06
210301	Гэрэл, цахилгаан	-	184,000.00
210302	Түлш, халаалт	-	209,308,874.06
210303	Цэвэр, бохир ус	-	5,200,000.00
210304	Байрны түрээс	-	7,862,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	127,134,643.40
210401	Бичиг хэрэг	-	41,156,059.40
210402	Тээвэр, шатахуун	-	28,251,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2,181,470.00
210404	Ном, хэвлэл	-	20,003,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	4,893,734.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	30,648,500.00
2105	Нормативд зардал	-	166,618,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	135,637,030.00
210502	Хоол, хүнс	-	3,946,510.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	27,035,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,606,325,659.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	570,937,975.00
210602	Тавилга	-	678,153,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	100,101,800.00
210604	Урсгал засвар	-	257,131,984.00
2107	Томилолт, зочны зардал	-	219,004,873.00
210702	Дотоод албан томилолт	-	219,004,873.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	96,375,738.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	66,690,978.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	29,396,000.00
210807	Газрын төлбөр	-	113,760.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	175,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	374,354,096.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	323,623,316.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	50,730,780.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,801,727,604.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,358,572,930.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	40,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,318,572,930.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	443,154,674.97
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	442,524,197.69

Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	630,477.28
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	168,094,170.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	168,094,170.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	168,094,170.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,703,034,270.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,703,034,270.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	30,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	728,562,204.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	285,218,936.66
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,658,753,129.14
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төвлөрүүлэн захирагч болон харьяа 24 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 17 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 17 харьяа байгууллагуудын 13 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 4 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 19,722.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,169.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлагыг хүргүүлж, 18,552.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн. Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хяналтыг сайжруулах, шийдвэрийг хэрэгжүүлэх, зөрчлийг багасгах талаар 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 7 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрснээс 4 байгууллагад зөрчлийн дүн өмнөх оноос 17,234.8 сая төгрөгөөр нэмэгдэж, давтагдан гарсан нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;”, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцруулсан, зөрчлийг давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох талаар төсвийн төвлөрүүлэн захирагчид албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6,295.1 сая төгрөгийн 44 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 3,137.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 29.5 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 2,173.3 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага хүргүүлэн, 934.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 35 зөвлөмжийг өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 3,311.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,202.8 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 518.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг хүргүүлж, 590.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны 144.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.", 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Төсвийн шууд захирагчийн татаас санхүүжилтийн авлагыг Сангийн яамтай эцэслэн тооцоо нийлээгүйгээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь байгууллагуудын аудит хийсэн тайлангаас нийт 373.1 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамтай татаас санхүүжилтийн тооцоог нийлж эцэслээгүй байхад авлагаар тайлагнаж, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд зөрүүтэй нэгтгэгдсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 23 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 131 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 6,295.1 сая төгрөгийн 44 алдаа, 3,137.7 сая төгрөгийн 71 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 19,722.2 сая төгрөгийн 16 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;," 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;," 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Тайлант онд Стандарт, хэмжил зүйн газрын харьяа байгууллагууд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 0.6 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 6.0 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 2.2 сая төгрөгийн, нийт 8.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын болон эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй таслан зогсоох

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны А/225 дугаар тушаалаар нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад балансын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалтай дүгнэлт авсан 4 байгууллагын 10 ажилтанд 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний буюу 13.9 сая төгрөгийн цалингийн урамшуулал олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалт бусаар зарцуулахгүй байх.

3. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар харьяалах нэгж байгууллагуудын авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 568.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6,295.1 сая төгрөгийн алдаа илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Стандарт, хэмжил зүйн газрын ТТЗ	5	2,202,834.2	1	102,500.0	4	2,100,334.2	5	2,202,834.2	-	-	-	-
Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ	4	3,442,218.8	-	-	4	3,442,218.8	4	3,442,218.8	-	-	-	-
ХАБҮЛЛ	4	49,599.3	4	49,599.3	-	-	4	49,599.3	-	-	-	-
Баянхонгор аймаг дахь СХЗХ	1	14,100.0	1	14,100.0	-	-	1	14,100.0	-	-	-	-
Булган аймаг дахь СХЗХ	1	300.0	-	-	1	300.0	1	300.0	-	-	-	-
Говь-Алтай аймаг дахь СХЗХ	1	2,520.2	-	-	1	2,520.2	1	2,520.2	-	-	-	-
Говьсүмбэр аймаг дахь СХЗХ	7	356,776.2	-	-	7	356,776.2	7	356,776.2	-	-	-	-
Дархан-Уул аймаг дахь СХЗХ	1	5,251.6	-	-	1	5,251.6	1	5,251.6	-	-	-	-
Дорноговь аймаг дахь СХЗХ	3	64,289.3	-	-	3	64,289.3	3	64,289.3	-	-	-	-
Дундговь аймаг дахь СХЗХ	1	452.0	1	452.0	-	-	1	452.0	-	-	-	-
Орхон аймаг дахь СХЗХ	1	5,730.0	-	-	1	5,730.0	1	5,730.0	-	-	-	-
Өвөрхангай аймаг дахь СХЗХ	3	2,733.4	1	57.6	2	2,675.8	3	2,733.4	-	-	-	-
Өмнөговь аймаг дахь СХЗХ	2	22,033.6	2	22,033.6	-	-	2	22,033.6	-	-	-	-
Сэлэнгэ аймаг дахь СХЗХ	1	2,638.4	-	-	1	2,638.4	1	2,638.4	-	-	-	-
Төв аймаг дахь СХЗХ	6	50,345.7	1	574.1	5	49,771.6	6	50,345.7	-	-	-	-
Увс аймаг дахь СХЗХ	1	54.8	1	54.8	-	-	1	54.8	-	-	-	-
Хөвсгөл аймаг дахь СХЗХ	1	54,002.1	1	54,002.1	-	-	1	54,002.1	-	-	-	-
Хэнтий аймаг дахь СХЗХ	1	19,216.8	1	19,216.8	-	-	1	19,216.8	-	-	-	-
Дүн	44	6,295,096.4	14	262,590.3	30	6,032,506.1	44	6,295,096.4	-	-	-	-

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 3,137.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 29.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,173.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 934.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг өгсөн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Стандарт, хэмжил зүйн газрын ТТЗ	6	1,108,782.0	0	-	3	518,014.5	3	590,767.5	-	-
Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ	15	1,664,995.9	4	12,003.1	4	1,390,336.3	7	262,656.5	-	-
ХАБҮЛЛ	9	237,183.7	3	7,151.8	3	221,711.4	3	8,320.5	-	-
Булган аймаг дахь СХЗХ	1	3,789.2	-	-	-	-	1	3,789.2	-	-
Говь-Алтай аймаг дахь СХЗХ	1	1,642.5	-	-	-	-	1	1,642.5	-	-
Говьсүмбэр аймаг дахь СХЗХ	10	17,758.4	2	716.5	4	16,079.9	4	962.0	-	-
Дархан-Уул аймаг дахь СХЗХ	1	1,645.9	1	1,645.9	-	-	-	-	-	-
Дорноговь аймаг дахь СХЗХ	1	2,787.4	-	-	-	-	1	2,787.4	-	-
Дорнод аймаг дахь СХЗХ	1	1,471.0	-	-	1	1,471.0	-	-	-	-
Дундговь аймаг дахь СХЗХ	4	2,462.5	-	-	3	991.5	1	1,471.0	-	-
Орхон аймаг дахь СХЗХ	3	7,471.0	-	-	2	7,471.0	1	-	-	-
Өмнөговь аймаг дахь СХЗХ	9	63,192.7	1	6,926.7	1	12,200.0	7	44,066.0	-	-
Сүхбаатар аймаг дахь СХЗХ	1	1,471.0	-	-	1	1,471.0	-	-	-	-
Сэлэнгэ аймаг дахь СХЗХ	2	3,114.5	1	1,028.9	1	2,085.6	-	-	-	-
Төв аймаг дахь СХЗХ	2	717.8	-	-	-	-	2	717.8	-	-
Хөвсгөл аймаг дахь СХЗХ	4	17,737.4	-	-	-	-	4	17,737.4	-	-
Хэнтий аймаг дахь СХЗХ	1	1,471.0	-	-	1	1,471.0	-	-	-	-
Дүн	71	3,137,693.9	12	29,472.9	24	2,173,303.2	35	934,917.8	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3 Нийцлийн аудиттай холбоотой нийт 19,722.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,169.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, 18,552.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Стандарт, хэмжил зүйн газар ТТЗ	1	-	-	-	1	-	-	-
Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ	1	18,291,911.4	-	-	-	-	1	18,291,911.4
ХАБҮЛЛ	1	284,932.9	-	-	1	284,932.9	-	-
Баян-Өлгий аймаг дахь СХЗХ	1	36,396.0	-	-	-	-	1	36,396.0
Баянхонгор аймаг дахь СХЗХ	1	14,100.0	-	-	-	-	1	14,100.0
Говьсүмбэр аймаг дахь СХЗХ	1	200,972.3	-	-	1	200,972.3	-	-
Дархан-Уул аймаг дахь СХЗХ	1	49,400.1	-	-	-	-	1	49,400.1
Төв аймаг дахь СХЗХ	1	-	-	-	1	-	-	-
Увс аймаг дахь СХЗХ	1	43,141.3	-	-	-	-	1	43,141.3
Дүн	9	18,920,854.0	-	-	4	485,905.2	5	18,434,948.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Стандарт, хэмжил зүйн газар ТШЗ	5	703,524.5	-	-	4	586,024.5	1	117,500.0
ХАБҮЛЛ	1	97,813.1	-	-	1	97,813.1	-	-
Говь-Алтай аймаг дахь СХЗХ	1	-	-	-	-	-	1	-
Дүн	7	801,337.6	-	-	5	683,837.6	2	117,500.0
Нийт дүн	16	19,722,191.6	-	-	9	1,169,742.8	7	18,552,448.8